



**ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 4/23

Улаанбаатар хот

**Ажилтан албан хаагчдын ажлын
үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг олгох
журам шинэчлэн батлах тухай**

Хөдөлмөрийн тухай хуулийн 101, 108 дүгээр зүйл, Эрчим хүчний үндэсний төв" ТӨХХК-ийн дүрмийн 9.9.10, Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний 3.29, "Эрчим хүчний үндэсний төв" ТӨХХК-ийн Захиргаа удирдлагын хэлтэс, ҮЭХ-ны хооронд 2023-2024 онд байгуулсан Хамтын гэрээний 3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрчим хүчний үндэсний төв" ТӨХХК-ийн ажилтан, албан хаагчдын ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг олгох журмыг Хавсралтаар баталсугай.

2. Компанийн тухайн жилийн зорилго, зорилтын биелэлт, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлт, бүтэц, нэгжийн ажилтнуудын тухайн сарын болон жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан нэмэгдэл хөлс, цалинг олгох журмыг үйл ажиллагаандаа баримталж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс болон Санхүү, эдийн засгийн хэлтэст тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Солонго)-т үүрэг болгосугай.

4. Тушаал батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/32 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.БЯМБАСҮРЭН

0005456

Эрчим хүчний үндэсний төв" ТӨХХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2024 оны 09 сарын 05-ны
өдрийн 1/23 тоот тушаалын хавсралт



КОМПАНИЙН АЖИЛТНУУДАД АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ТООЦОЖ
НЭМЭГДЭЛ ХӨЛС, ЦАЛИН ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Компанийн тухайн жилийн зорилго, зорилтын биелэлт, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлтийг хангах, компанийн үйл ажиллагааг жигд явуулахад бүтэц, нэгжийн ажилтнуудын бүтээлч, идэвх санаачилгыг дэмжиж, ажлын үр дүнгээр нэмэгдэл хөлс, цалинг олгоход энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Тухайн жилийн үр дүнгээр олгох нэмэгдэл хөлс, цалинг олгохдоо Хөдөлмөрийн тухай хууль болон тус компанийн Захиргаа, удирдлагын хэлтэс Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд 2023-2024 онд байгуулсан Хамтын гэрээ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/192 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам" болон энэхүү журмыг тус тус баримтална.
- 1.3. Тухайн жилийн үр дүнгээр олгох нэмэгдэл хөлс, цалингийн санг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах бөгөөд уг цалингийн санд багтааж урамшуулалт цалингийн сарын хувь хэмжээг Захирлын зөвлөлийн хурлын шийдвэр, жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг компанийн Захирлын зөвлөлийн хурал болон ТУЗ-ийн цалин хөлсний хорооны дүгнэлтийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөл хэлэлцэж тогтооно.
- 1.4. Ажилтнуудад ажлын үр дүнгээр нэмэгдэл хөлс, цалинг тооцож олгохдоо компанийн дотоод хэм хэмжээ, дүрэм, журам, тушаал шийдвэрийг мөрдлөг болгоно.

ХОЁР. ТУХАЙН САРЫН АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР НЭМЭГДЭЛ ХӨЛС,
ЦАЛИН ОЛГОХ ҮНДСЭН ЗОХИЦУУЛАЛТ

- 2.1. Компанийн санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх үүднээс бүтэц, нэгжийн ажилтнуудын бүтээлч, идэвх санаачилгатай байдлыг дэмжиж, тэдгээрийн ажлын гүйцэтгэлийг дүгнэж, тухайн сарын ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн нэмэгдэл хөлс, цалинг олгоно.
- 2.2. Компанийн сарын ажлын үр дүнгээр нэмэгдэл хөлс, цалинг олгохдоо бүтэц, нэгжийн ажилтны албан тушаалын үндсэн болон тарифт цалингийн 50 хүртэл хувиар тооцно.
- 2.3. Компанийн бүтцийн нэгжүүд нь сар бүрийн 20-ны дотор өмнөх сарын ажлын тайлангаа Захиргаа хариуцсан нэгжид хүргүүлж, тус нэгж нь үнэлгээг Гүйцэтгэх захиралд танилцуулан баталгаажуулна.

- 2.4. Захиргаа хариуцсан нэгжийн баталгаажуулсан сарын ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалингийн тушаалыг үндэслэн санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан нэгж сарын сүүлийн цалин дээр бодож олгоно.
- 2.5. Гүйцэтгэх захирлын тушаалаар сахилгын шийтгэл хүлээсэн ажилтанд тухайн шийтгэлтэй сараас бусад сард үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг олгож болно.
- 2.6. Бүтэц, нэгжийн дарга ажилтнуудынхаа ажлын үр дүнг дүгнэн нэмэгдүүлсэн болон хасагдуулсан үндэслэлээ нэгжийн хурлаараа нээлттэй хэлэлцэнэ.
- 2.7. Ажил үүргийг хавсран, орлон ажилласан ажилтанд сарын үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг зөвхөн өөрийн албан тушаалын үндсэн цалингаас бодож олгоно.
- 2.8. Үндсэн ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөн компанийн нэрийн өмнөөс тэмцээн, уралдаанд оролцож байгаа ажилтан, компанийн захиалгаар сургалтад суралцаж буй ажилтнуудад сарын ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг олгоно.
- 2.9. Сургалтад хамрагдаж буй ажилтанд олгох сарын үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг нь нэг сараас хэтрэхгүй.

ГУРАВ. ЖИЛИЙН АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР НЭМЭГДЭЛ ХӨЛС, ЦАЛИН ОЛГОХ ҮНДЭСЛЭЛ

- 3.1. Компани стратеги төлөвлөгөөнд тулгуурлан нэгжүүд тухайн жилийн зорилго, зорилт, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж компанийн Захирлын зөвлөл, Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулна.
- 3.2. Компанийн хэлтэс, нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг Захирлын зөвлөлийн хуралд тайлагнах бөгөөд компанийн гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэрийн хэрэгжилт, ажлын бүтээлч байдал, жилийн эцсийн тайлан хамгаалалт зэрэг ажлын үр дүн нь тухайн жилийн ажлын үр дүн олгох үндэслэл болно.
- 3.3. Ажилтнуудад олгох жилийн ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалингийн хэмжээ нь Захиргаа удирдлагын хэлтэс Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд 2023-2024 онд байгуулсан Хамтын гэрээнд заасан хэмжээнээс хэтрэхгүй.
- 3.4. Жилийн ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг олгохдоо удирдах ажилтнууд өөрийн харъяа хэлтэс, нэгжийн ажлын тайланг захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж дүгнүүлсэн байна.
- 3.5. Сахилгын шийтгэл хүлээсэн ажилтанд хугацаанаас өмнө тушаалаар сахилгын шийтгэлгүйд тооцуулсан бол жилийн ажлын үр дүнгийн урамшуулалт цалинг олгож болно.
- 3.6. Тухайн жилийн 6 болон түүнээс дээш сарын хугацаанд ажилласан үед жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг олгоно.


ДӨРӨВ. АЖЛЫН ҮР ДҮНГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ

- 4.1. Компанийн бүтэц, нэгжүүдийн ажлын үр дүнг дүгнэх үзүүлэлтүүд нь тодорхой, ойлгомжтой байх ба ажилтны ажлын үр дүнг үнэн зөв, оновчтой дүгнэсэн байна.
- 4.2. Тухайн жил болон сарын цалингийн санд багтааж, олговол зохих хувийг нэмэгдүүлэх, бууруулах байдлаар ажлын үр дүнгээр нэмэгдэл хөлс, цалин тооцохдоо хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг харгалзан дүгнэнэ. Үүнд:
 - 4.2.1 Удирдах ажилтнуудын сарын ажлын үр дүнгийн үзүүлэлт /Хүснэгт 1/
 - 4.2.2. Хэлтэс, алба, нэгжийн ажилтнуудын сарын ажлын үр дүнг тооцох үзүүлэлтүүд /Хүснэгт 2/
- 4.3. Захиргаа удирдлагын хэлтэс нь энэхүү журмын дагуу ажилтнуудын сарын ажлын үр дүнгийн үзүүлэлтүүдийг нэгтгэн дүгнэж, гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулна.
- 4.4. Тухайн сарын ажлын үр дүнгийн үзүүлэлтүүдийг дүгнэхэд шаардлагатай мэдээ, тайлан, санхүүгийн тооцоонуудыг хариуцсан хэлтэс, нэгж нь тухай бүр Захиргаа удирдлагын хэлтэс болон Санхүү эдийн засгийн хэлтэст хүргүүлнэ.
- 4.5. Тухайн хэлтэс, алба, нэгжид жилийн ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг хуваарилахдаа жилийн эцсийн тайлан хамгаалалтын үр дүнг харгалзан Захирлын зөвлөлөөс тогтоосон олговол зохих хувь хэмжээгээр ногдуулна.
- 4.6 Бүтэц, нэгжийн удирдлагуудын жилийн ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалингийн хэмжээг тооцохдоо тухайн хэлтэс, нэгжийн ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үр дүнгийн дундаж үзүүлэлтээр дүгнэн тооцож олгоно.
- 4.7. Журамд заасны дагуу бүтэц, нэгжийн дүгнэсэн үзүүлэлтүүдэд харгалзах хувь хэмжээг гүйцэтгэх захирал өөрчилж болно.
- 4.8. Тухайн жилд 6 сараас дээш хугацаанд ажилласан боловч бүтэн жил хүрээгүй тохиолдолд ажилласан хугацаанд харгалзан тооцож үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг олгоно.

ТАВ. АЖИЛТНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ҮР ДҮНД ҮНДЭСЛЭН ЦАЛИНГИЙН ШАТЛАЛ НЭМЭГДҮҮЛЭХ НӨХЦӨЛ

- 5.1. Ажилтны бүтэн жилийн ажлын үнэлгээнээс шалтгаалан үндсэн цалингийн шатлалыг өсгөх эсхүл бууруулах асуудлыг компанийн санхүүгийн нөхцөл байдалд тулгуурлан дараах байдлаар шийдвэрлэнэ.
 - 5.1.1. Үнэлгээний дундаж оноог 0-75 бол "Хангалтгүй"-д тооцож үндсэн цалингийн шатлалыг бууруулах
 - 5.1.2. Үнэлгээний дундаж 76-97 бол "Хангалттай"-д тооцож үндсэн цалингийн шатлалыг хэвээр үлдээх,
 - 5.1.3. Үнэлгээний дундаж 98-100 бол "Онц"-д тооцож үндсэн цалингийн шатлалыг нэг шатаар өсгөж болно.

“Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2024... оны 09 сарын 25-ны
өдрийн 1/23 тоот тушаалын хавсралт



КОМПАНИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН
..... ДУГААР САРЫН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Албан тушаалын нэр.....

Удирдлагын нэр.....

Жич: 100 оноо- ...хувь

Д/д	Дүгнэх үзүүлэлт	Олговол зохих оноо	Олгосон оноо	Тайлбар
1	Нэгжийн үндсэн чиг үүрэг, төлөвлөгөөт ажлын биелэлт	30		
2	Компанийн төвлөрүүлбэл зохих орлогын биелэлт	20		
3	Ажлын цаг ашиглалт	10		
4	Үүрэг даалгаврын биелэлт /захирлын зөвлөлийн болон нэгдсэн шуурхай, хугацаатай албан бичгийн шийдвэрлэлт г.м/	20		
5	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм журмын мөрдөлт	20		
Нийт үүрэг даалгаврын биелэлтийн хувь		100		

... оноо-.....хувь

ХЯНАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/

/

ДҮГНЭСЭН:

ЗАХИРГАА, УДИРДАГАЙН ХЭЛТСИЙН ДАРГА

/

/

“Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2024. оны 09. сарын 25-ны
өдрийн 7/23 тоот тушаалын хавсралт



КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛТНУУДЫН
..... ДУГААР САРЫН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Албан тушаалын нэр.....

Ажилтны нэр.....

Жич: 100 оноо-..... хувь

Д/д	Дүгнэх үзүүлэлт	Олговол зохих оноо	Олгосон оноо	Тайлбар
1	Удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгавар болон АБТ заагдсан үндсэн чиг үүргийн биелүүлсэн байдал	30		
2	АХХ, баримт бичгийн стандарт хангаж ажилласан байдал болон санхүүгийн тооцоо нийлсэн байдал (төсөв, томилолтын зардал, шатахуун гм)	20		
3	Ажлын цаг ашиглалт	20		
4	Компанийн үйл ажиллагаатай холбоотой олон нийтийн арга хэмжээнд идэвхитэй оролцсон байдал	10		
5	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага ханган ажилласан байдал	20		
Нийт үүрэг даалгаврын биелэлтийн хувь		100 хувь		

..... оноо-..... хувь

ХЯНАСАН:
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР / /
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА / /

ДҮГНЭСЭН:
ХЭЛТЭС, НЭГЖИЙН ДАРГА / /